

Аудитын код: САГ-2018/14/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Үндсэн хөрөнгийн талаар.....	4
2.9.2	Авлага, өглөгийн талаар.....	4
2.9.3	Санхүүгийн тайлагналын талаар.....	5
2.9.4	Малын бүртгэлийн талаар.....	5
2.9.5	Бүтэц, зохион байгуулалтын талаар	5
2.9.6	Санхүүгийн тайлагналын талаар.....	6
2.9.7	Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал	8
3.1	Бүтэц, зохион байгуулалтын талаар	9
3.2	Санхүүгийн тайлагналын талаар.....	10
3.3	Малын бүртгэлийн талаар	11
3.4	Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар	11
3.5	Хандивын хөрөнгийн талаар	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.5	Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
5.	Аудитын хураангуй тайлангийн хавсралт	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
САНГИЙН ЗАХИРАЛ Д.ЭНХЖАРГАЛ
ТАНАА

2018.03.23 № 06/816
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG24.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

071458

Аудитын гол асуудал

Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд


- 1,464.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн,
- 412.9 сая төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Шинжлэх ухаан технологийн сангийн захирал Д.Энхжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн бүтэц, зохион байгуулалтыг баталгаажуулах, хандивын хөрөнгө, малыг зөв үнэлж, бүртгэх, улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх, аудитад бүрэн хамруулах талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 6-наас 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийж, Төрийн аудитын байгууллага баталгаажуулж, Шинжлэх ухаан технологийн сангийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ажлах аудитор Д.Цэрэндорж, аудитор Ц.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.



Аудитаар Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Шинжлэх ухаан технологийн сангийн 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 1/43 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шинжлэх ухаан технологийн сан санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Шинжлэх ухаан технологийн сангийн алсын хараа

Оновчтой санхүүжилт, бодит хяналт, ашигтай үр дүнгийн төлөө шинжлэх ухаанд үйлчилж, сангаа арвижуулна.

Шинжлэх ухаан технологийн сангийн эрхэм зорилго

Шинжлэх ухаан технологийн сан нь судалгаа боловсруулалтын ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүжүүлэх, төслийн явц, үр дүн, зарцуулалтад хяналт тавих, нэгтгэн тайлагнах, төслийн тайлан мэдээллийг итгэмжлэн хадгалах, сурталчлах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

Шинжлэх ухааны технологийн сан нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн төслүүдийг дэмжин хөгжүүлэх, хуримтлал бий болгох, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, үр ашгийг нийтийн хүртээл болгоход санхүүгийн баталгаатай эх үүсвэрээр хангах,
- Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх механизмыг бий болгох,
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, эрдмийн зэрэг хамгаалсан диссертацийг фондонд хадгалж, Монгол улсын “Оюуны сан”-г бүрдүүлэх, хамгаалах, сурталчлах, эдийн засгийн эргэлтэд оруулах,
- Гадаадтай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад улсын ноу-хау оруулж ирэх, нутагшуулах,

Шинжлэх ухаан технологийн сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг гол шалгуур болголоо.

Аудитаар Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримтталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 17 горимт тусгай гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/



Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Шинжлэх ухааны академи нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шинжлэх ухаан технологийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод аудитын алба байхгүй, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Шинжлэх ухаан технологийн сан 4 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 17,641.5 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 16,947.5 сая төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь улсын төсвийн санхүүжилт дутуу санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд улсын төсвийн санхүүжилт 639.0 сая төгрөгөөр дутуу санхүүжигдэн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 406.7 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 3.1 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.


2.7 Шилэн дансны мэдээлэл

Шинжлэх ухаан технологийн сан нь Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.



Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд харьяа 12 хүрээлэнгийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар хүрээлэнгүүд “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

2.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны үндсэн хөрөнгийн бүртгэлд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- ✓ Тайлант онд 1,464.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэргүйгээр бэлтгэсэн байна. Тухайлбал: Ургамал газар тариалангийн хүрээлэн 789.5 сая, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв 457.0 сая, Мал эмнэлгийн хүрээлэн 84.5 сая, Цөмийн физикийн судалгааны төв 81.7 сая, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн 45.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зохих шийдвэргүй бэлтгэж, Ургамал газар тариалангийн хүрээлэн 130.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр данснаас хассан байна.
- ✓ Ургамал газар тариалангийн хүрээлэн нь нэг еврогийн үнэтэй 20 нэр төрлийн нийт 20 еврогийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг 19,119.0 еврогийн тээврийн зардал төлж, хандиваар авсан хөрөнгийг 84,581.2 еврогоор үнэлж бүртгэсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4-т “... төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх ... саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах”,

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, ... шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ”, 4.3-т “... улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, ... тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам, Шинжлэх Ухаан технологийн сангийн 2015 оны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх;

2.9.2 Авлага, өглөгийн талаар

2017 оны жилийн эцсийн байдлаар 412.9 сая төгрөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй. Үүнд:

- ✓ Авлагын 27.1 хувь буюу 354.7 сая төгрөгийг /Ургамал газар тариалангийн хүрээлэн 185.6 сая, Шинжлэх ухаан технологийн сан 68.6 сая, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн 46.2 сая, Уул уурхайн хүрээлэн 21.1 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 20.5 сая, Дулаан техник, үйлдвэрлэлийн технологийн хүрээлэн 12.4 сая төгрөгийн авлагатай/

- ✓ Өглөгийн 43.5 хувь буюу 58.2 сая төгрөгийг /Ургамал газар тариалангийн хүрээлэн 48.9 сая, Мал эмнэлгийн хүрээлэн 5.7 сая, Дулаан техник, үйлдвэрлэлийн технологийн хүрээлэн 2.0 сая, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн 1.5 сая төгрөгийн өглөгтэй/ тус тус баталгаажуулаагүй байна.

Хөнгөн үйлдвэр судалгаа хөгжлийн хүрээлэн нь 57.1 сая төгрөгийн авлагыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн удирдах зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 13 дугаар тогтоолоор хуримтлагдсан үр дүн данс руу хаасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч ...”, 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ... ”, 20.2.6-д “ ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлэх;

2.9.3 Санхүүгийн тайлагналын талаар

Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэх 12 хүрээлэн Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “ ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж ... ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангаа цаглабарт хугацаанд ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх;

2.9.4 Малын бүртгэлийн талаар

Ургамал газар тариалангийн хүрээлэн нь 209 толгой малыг 0.7 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”,

НББОУС 41 Хөдөө аж ахуй, “Бодит үнэ: холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгийг солилцох, ...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС 41-ийг хэрэгжүүлж, малыг зөв үнэлж бүртгэх талаар зөвлөмж хүргүүлэх;

2.9.5 Бүтэц, зохион байгуулалтын талаар

Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор яамд болон их сургуулиудын харьяалалд хувиарлан зохион байгуулсан байна. Үүнд: ХААИС-ийн харьяа 4 хүрээлэн, ШУТИС-ийн харьяа 3 хүрээлэн, МУИС-ийн харьяа 2 хүрээлэн, БСШУЯ, ЭМЯ, АШУҮИС-ийн харьяа тус бүр нэг, нийт 12 хүрээлэн Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжилт авч, санхүүгийн тайлангаа нэгтгүүлж байна. Тус хүрээлэнгүүдэд бүтэц зохион байгуулалт хийх, удирдлагын томилгоог харьяалах яам, их сургуулиуд хийж байгаагаас хүрээлэнгүүд хоёрдмол удирдлагатайгаар ажиллаж байгаа нь эрдэм шинжилгээний ажлын үр дүнд санхүүгийн сахилга бат алдагдахад нөлөөлж байна. Тухайлбал: ХААИС-ийн захирлын 2017 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн Б/36 дугаар тушаалаар Дархан-Уул аймаг дахь Ургамал газар тариалангийн

хүрээлэнг Ургамал газар тариалангийн хүрээлэн, Агроэкологи бизнесийн сургууль гэж салган зохион байгуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний бүрэн эрх 15.3-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно", 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, Засгийн газрын тогтоол гаргуулж, эрдэм шинжилгээний байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангаж, санхүүгийн сахилга батыг сайжруулан ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

2.9.6 Санхүүгийн тайлагналын талаар

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн тайланд 4 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгддэг ба дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✓ Архангай аймаг дахь Өндөр Уулын бүсийн хөдөө аж ахуй эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн станцын санхүүгийн тайланд аудит хийгдээгүй,
- ✓ Өмнөговь аймаг дахь Говийн бүсийн бэлчээрийн мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн тайланд аудит хийгдээгүй,
- ✓ Төв аймгийн Батсүмбэр дэх Зөгийн аж ахуй эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн станц санхүүгийн тайлан бэлтгээгүй,
- ✓ ХААИС-ийн харьяа Дорнод бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн хүрээлэнгийн санхүүгийн тайланд сөрөг санал дүгнэлт өгөгдсөн,
- ✓ Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн ХААИС-ийн харьяа Улаангом дахь Газар тариалангийн эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн станцын санхүүгийн тайланд аудит хийгдээгүйгээр нэгтгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана", 9.7-д "Аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт өөрийн цахим хуудсанд байршуулж ил тод болгож болно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг зөрчсөн байна.


Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангаа үнэн зөв гаргаж, аудит хийлгэж байх талаар зөвлөмж хүргүүлэх;

2.9.7 Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар

Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнг Төрийн өмчит үйлдвэрийн газар гэж тогтоосон. Тус хүрээлэн Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байна.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь ... улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргана" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;



2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар эрдэм шинжилгээний ажлын зардал, төслийн үр дүн, бий болсон биет болон биет бус хөрөнгийн бүртгэл зэргийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 4,513.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 958.3 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 5.0 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 1,888.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 1,661.2 сая төгрөгийн зөрчилд 51 зөвлөмж хүргүүлсэн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Шинжлэх ухаан технологийн сангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 9 зөвлөмж өгөгдсөн ба эдгээрээс тус бүр 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 18,395.3 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 184.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 1,464.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн, 412.9 сая төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Шинжлэх ухаан технологийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Шинжлэх ухаан технологийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Бүтэц, зохион байгуулалтын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор яамд болон их сургуулиудын харьяалалд хувиарлан зохион байгуулсан байна. Үүнд: ХААИС-ийн харьяа 4 хүрээлэн, ШУТИС-ийн харьяа 3 хүрээлэн, МУИС-ийн харьяа 2 хүрээлэн, БСШУЯ, ЭМЯ, АШУУИС-ийн харьяа тус бүр нэг, нийт 12 хүрээлэн Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжилт авч, санхүүгийн тайлангаа нэгтгүүлж байна. Тус хүрээлэнгүүдэд бүтэц зохион байгуулалт хийх, удирдлагын томилгоог харьяалах яам, их сургуулиуд хийж байгаагаас хүрээлэнгүүд хоёрдмол удирдлагатайгаар ажиллаж байгаа нь эрдэм шинжилгээний ажлын үр дүн, санхүүгийн сахилга бат алдагдахад нөлөөлж байна. Тухайлбал: ХААИС-ийн захирлын 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Б/36 дугаар тушаалаар Дархан-Уул аймаг дахь Ургамал газар тариалангийн хүрээлэнг Ургамал газар тариалангийн хүрээлэн, Агроэкологи бизнесийн сургууль гэж салган зохион байгуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний бүрэн эрх 15.3-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно", 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд хангагдахгүй;

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, Засгийн газрын тогтоол гаргуулж, эрдэм шинжилгээний байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангаж, санхүүгийн сахилга батыг сайжруулан ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 Санхүүгийн тайлагналын талаар**Тэргүүлэх ач холбогдол №2****ҮАГ-ын ажиглалт**

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн тайланд 4 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгддэг ба дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Архангай аймаг дахь Өндөр Уулын бүсийн хөдөө аж ахуй эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн станцын санхүүгийн тайланд аудит хийгдээгүй,
- Өмнөговь аймаг дахь Говийн бүсийн бэлчээрийн мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн тайланд аудит хийгдээгүй,
- Төв аймгийн Батсүмбэр дэх Зөгийн аж ахуй эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн станц санхүүгийн тайлан бэлтгээгүй,
- ХААИС-ийн харьяа Дорнод бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн хүрээлэнгийн санхүүгийн тайланд сөрөг санал дүгнэлт өгөгдсөн,

Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн ХААИС-ийн харьяа Улаангом дахь Газар тариалангийн эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн станцын санхүүгийн тайланд аудит хийгдээгүйгээр нэгтгэгдсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана”, 9.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт өөрийн цахим хуудсанд байршуулж ил тод болгож болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хууль зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангаа үнэн зөв гаргаж, аудит хийлгэж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.3 Малын бүртгэлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн 209 толгой малыг 0.7 сая төгрөгөөр бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”,

НББОУС 41 Хөдөө аж ахуй, “Бодит үнэ: холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгийг солилцох, ...”, гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС 41-ийг хэрэгжүүлж, малыг зөв үнэлж бүртгэх:

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.4 Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнг Төрийн өмчит үйлдвэрийн газар гэж тогтоосон. Тус хүрээлэн Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байна.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь ... улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргана” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;



3.5 Хандивын хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Ургамал газар тариалангийн хүрээлэн нь нэг еврогийн үнэтэй 20 нэр төрлийн нийт 20 еврогийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг 19,119.0 еврогийн тээврийн зардал төлж, хандиваар авсан хөрөнгийг 84,581.2 еврогоор үнэлж бүртгэсэн.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 4.3-т "... улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, ... тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ",

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө буруу үнэлэгдэх, үрэгдэх, шамшигдах;

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлж, хандиваар авсан хөрөнгийг дахин нягталж, зөв бүртгэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/


Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3а, 3б	422,709.5	148,297.1
Авлага	5а, 5б, 6а, 6б	1,769,781.2	1,306,868.2
Урьдчилж төлсөн зардал	7а, 7б	55,154.8	8,717,861.5
Бараа материал	8а, 8б, 8в	2,003,759.7	2,218,293.1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		4,251,405.2	12,391,319.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	12а, 12б, 12в	12,211,079.3	13,207,607.1
Биет бус хөрөнгө	13	43,017.0	59,387.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		12,254,096.3	13,266,994.2
ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН		16,505,501.5	25,658,314.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б		
Өглөг	17а, 17б	91,579.7	186,967.6
Урьдчилж орсон орлого	18а, 18б	75.0	476,217.2
Богино хугацаат өр төлбөрийн дүн		91,654.7	663,184.8
Урт хугацаат зээл	20а, 20б	182,031.9	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		182,031.9	384,923.2
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		273,686.6	1,048,108.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ			
Засгийн газрын хувь оролцоо		16,231,814.9	24,610,206.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		16,231,814.9	24,610,206.1
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН НИЙТ ДҮН		16,505,501.5	25,658,314.1

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО			
Татварын бус орлого /хураамж, өмчийн орлого, торгууль/	1а, 1б	3,892,039.0	5,436,292.4
Буцалтгүй тусламжийн орлого	1а, 1б	17,233,389.3	20,378,462.9
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН НИЙТ ДҮН		21,125,428.3	25,814,755.3
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
УРСГАЛ ЗАРДАЛ			
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж		8,218,015.1	8,016,128.1
Татаас болон шилжүүлгийн төлбөр		189,681.7	592,067.0
Бараа, үйлчилгээний зардал		1,749,829.4	1,436,367.9
Нийгмийн хамгааллын зардал		330,503.9	471,125.6
Элэгдэл, хорогдлын зардал		1,634,560.1	1,789,637.9
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал		9,585,838.2	6,089,941.9
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	2а, 2б	21,708,428.5	18,395,268.3
Үндсэн үйл ажиллагааны нийт ашиг/(алдагдал)		15.0	58,261.8
Үндсэн хөрөнгө борлуулсны олз (гарз)		15.0	58,261.8
Тайлант үеийн цэвэр ашиг/(алдагдал)		15.0	58,261.8



4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,795,665.8	-	16,795,665.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,795,665.8	-	16,795,665.8
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн	294,792.2	-	294,792.2
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	(858,643.2)	-	(858,643.2)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,231,814.9	-	16,231,814.9
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	902,924.8	-	902,924.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,134,739.7	-	17,134,739.7
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн	(2,282.5)	-	(2,282.5)
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	7,477,748.9	-	7,477,748.9
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,610,206.1	-	24,610,206.1

4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хүлээн авсан мөнгөн хөрөнгө:		
Татварын бус орлого /хураамж, өмчийн орлого, торгууль/	3,699,572.8	3,511,437.7
Буцалтгүй тусламжийн орлого	18,071,521.6	21,551,488.4
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн	21,771,094.4	25,062,926.0
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж	8,327,568.2	7,926,888.1
Татаас болон шилжүүлгийн төлбөр	558,565.5	775,915.5
Бараа, үйлчилгээний зардал	1,581,502.0	1,366,082.7
Нийгмийн хамгааллын зардал	328,661.3	492,142.1
Үйл ажиллагааны бусад зардал	10,532,824.2	13,999,145.8
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийн нийт дүн	21,329,121.2	24,560,174.2
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	441,973.2	502,751.8
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Биет болон биет бус үндсэн хөрөнгө худалдан авалт	388,196.2	710,226.2
Хөрөнгө оруулалт цэвэр мөнгөн гүйлгээ	388,196.2	710,226.2
Хүлээн авсан мөнгөн хөрөнгө:		
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Бонд, зээлийн эргэн төлөлт		66,938.0
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		66,938.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	53,777.0	(274,412.4)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	368,932.6	422,709.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	422,709.6	148,297.2



4.5 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		22,101.6		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,641,482.5	16,947,510.1	(693,972.4)	96.1
УРСГАЛ ЗАРДАЛ	17,641,482.5	16,947,510.1	(693,972.4)	96.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,343,582.5	16,661,190.7	(682,391.8)	96.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,535,480.0	5,479,251.4	(56,228.6)	99.0
Үндсэн цалин	4,754,738.6	4,858,651.9	103,913.3	102.2
Нэмэгдэл	539,749.7	445,778.7	(93,971.0)	82.6
Унаа хоолны хөнгөлөлт	240,991.7	174,820.8	(66,170.9)	72.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	633,574.6	627,797.1	(5,777.5)	99.1
Тэтгэврийн даатгал	413,999.3	408,776.3	(5,223.0)	98.7
Тэтгэмжийн даатгал	57,441.7	48,435.2	(9,006.5)	84.3
ҮОМШӨ-ний даатгал	41,613.3	50,478.1	8,864.8	121.3
Ажилгүйдлийн даатгал	10,956.6	11,045.8	89.2	100.8
Эрүүл мэндийн даатгал	109,563.7	109,061.8	(501.9)	99.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	461,486.8	446,505.0	(14,981.8)	96.8
Гэрэл, цахилгаан	151,687.5	181,818.9	30,131.4	119.9
Түлш, халаалт	164,368.5	122,006.1	(42,362.4)	74.2
Цэвэр, бохир ус	34,003.6	29,591.0	(4,412.6)	87.0
Байрны түрээс	111,427.2	113,089.0	1,661.8	101.5
Хангамж, бараа материалын зардал	107,540.5	104,310.2	(3,230.3)	97.0
Бичиг хэрэг	14,676.4	18,182.8	3,506.4	123.9
Тээвэр, шатахуун	17,384.3	16,157.2	(1,227.1)	92.9
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	48,255.2	43,654.7	(4,600.5)	90.5
Ном, хэвлэл	6,593.4	4,040.5	(2,553.0)	61.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,139.4	920.0	(219.4)	80.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,491.8	21,355.0	1,863.2	109.6
Нормативт зардал	5,327.2	5,091.1	(236.1)	95.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,327.2	5,091.1	(236.1)	95.6
Эд хогшил, урсгал засварын зардал	85,757.7	85,633.9	(123.8)	99.9
Багаж, техник, хэрэгсэл	26,000.0	25,991.2	(8.8)	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	278.0	270.0	(8.0)	97.1
Урсгал засвар	59,479.7	59,372.7	(107.0)	99.8
Томилолт, зочны зардал	55,839.6	55,119.9	(719.7)	98.7
Дотоод албан томилолт	55,839.6	55,119.9	(719.7)	98.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,440,300.1	9,839,737.8	(600,562.3)	94.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,390,931.8	9,803,942.4	(586,989.4)	94.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	17,260.0	7,020.0	(10.2)	40.7
Даатгалын үйлчилгээ	930.3	903.0	(27.3)	97.1
Тээврийн хэрэгслийн татвар	2,136.8	1,364.1	(772.7)	63.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	393.0	112.0	(281.0)	28.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,557.2	15,556.3	(85.0)	100.0
Газрын төлбөр	13,081.0	10,840.0	(2241.0)	82.9
Бараа үйлчилгээний бусад зардал	18,276.0	17,744.3	(531.7)	97.1
Бараа үйлчилгээний бусад зардал	13,900.0	13,529.3	(370.7)	97.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,376.0	4,215.0	(161.0)	96.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	297,900.0	286,319.4	(11,580.6)	96.1
Бусад урсгал шилжүүлэг	297,900.0	286,319.4	(11,580.6)	96.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	105,000.0	104,519.4	(480.6)	99.5

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	192,900.0	181,800.0	(11,100.0)	94.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,641,482.5	16,928,474.9	(713,007.6)	96.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,142,366.4	16,503,394.6	(638,971.8)	96.3
Улсын төсвөөс санхүүжих	17,142,366.4	16,503,394.6	(638,971.8)	96.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	499,116.1	425,080.4	(74,035.7)	85.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	427,615.3	406,720.3	(20,895.0)	95.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,500.8	18,360.0	(53,140.8)	25.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,066.5		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	13	13	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	654	626	-28	95.7
Удирдах ажилтан	13	12	-1	92.3
Гүйцэтгэх ажилтан	496	513	17	103.4
Үйлчлэх ажилтан	145	101	-44	69.7

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5. АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2017 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2018/14/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Шинжлэх ухаан технологийн сан			Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Тайлант онд 1,464.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэргүйгээр бэлтгэсэн, Ургамал газар тариалангийн хүрээлэн нь нэг еврогийн үнэтэй 20 нэр төрлийн нийт 20 еврогийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг 19,119.0 еврогийн тээврийн зардал төлж, хандиваар авсан хөрөнгийг 84,581.2 еврогоор үнэлж бүртгэсэн.	1,464.0	Албан шаардлага	Захирал	Д.Энхжаргал
				Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга	Б.Отгонжаргал
2	2017 оны жилийн эцсийн байдлаар 412.9 сая төгрөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй	412.9	Албан шаардлага	Захирал	Д.Энхжаргал
				Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга	Б.Отгонжаргал
Нийт дүн		1,876.0			

